



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

/ЗТХЯ-ны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээ 3 дугаар улирлын байдлаар/

2019.10.01

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээний зорилго, үндэслэл, арга зүй

Хяналт-шинжилгээ хийх зорилго нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтыг хангахад чиглэгдсэн арга хэмжээний гүйцэтгэлийн явцын талаар дүгнэлт гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтанд бодит мэдээлэл өгсний үндсэн дээр төлөвлөсөн арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлэх зохион байгуулалт, зохицуулалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Эрх зүйн үндэслэл нь “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2018 оны 37 дугаар тогтоол, “Төлөвлөгөө батлах тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 296 дугаар тушаал болно. Эдгээр тогтоол, тушаалын заалтын дагуу хэрэгжүүлсэн ажлын явцад хийсэн хяналт-шинжилгээний тайлан, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийн хамт Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх ба энэ нь Засгийн газраас тус яамны үйл ажиллагааг үнэлж дүгнэх нэг шалгуур үзүүлэлт болохын зэрэгцээ яамны ерөнхий менежер, нэгжийн менежерүүдийн үйл ажиллагаа, үр дүнгийн гэрээний биелэлтийн түвшинг үнэлж, дүгнэх нэг үзүүлэлт болох ач холбогдолтой.

Арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн түвшингийн хувийг тогтоохдоо Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ыг баримталсан болно.

Хоёр. Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн явц

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 296 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа. Зам, тээврийн салбарт 6 зорилтыг хэрэгжүүлэх нийт 31 арга хэмжээний хэрэгжилтийг үнэллээ. Үүнд:

- Авто замын салбарт 2 зорилтыг хэрэгжүүлэх 20 арга хэмжээ
- Төмөр зам, далайн тээврийн салбарт 2 зорилтыг хэрэгжүүлэх 5 арга хэмжээ
- Агаарын тээврийн салбарт 1 зорилтыг хэрэгжүүлэх 2 арга хэмжээ
- Автотээврийн салбарт 2 зорилтыг хэрэгжүүлэх 3 арга хэмжээ
- Хот, суурин, хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх 1 арга хэмжээ

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ын дагуу Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 31 арга хэмжээний хэрэгжилтийг 2019 оны 3 дугаар улирлын байдлаар авч үзвэл **дунджаар 72.8 хувийн биелэлттэй** үнэлэгдлээ.


Хэрэгжилтийг давхардсан тоогоор газар, хэлтэс тус бүрээр авч үзвэл:

Хүснэгт 1

№	ГАЗАР, ХЭЛТЭС	Нийт заалт	100	70	40	0	Үнэлэх боломжгүй	Хувь
1	АЗБХЗГ	20	9	8	3	-	-	79
2	АТБХЗГ	2	-	-	2	-	-	40
3	ТЗДТБХЗГ	5	2	-	1	1	1	60
4	АТБХЗХ	2	-	-	-	-	2	-
5	БТГ	1	-	-	1	-	-	40
6	ИНЕГ	2	-	-	-	-	2	-
7	“МТЗ” ТӨХК	1	-	-	-	-	1	-
8	“УБТЗ” ХНН	2	1	-	1	-	-	70
9	“Нортерн рейлвейс” ХХК	1	-	-	-	1	-	0
10	Төслийн нэгж	1	1	-	-	-	-	100
11	НЗДТГ	6	1	3	2	-	-	65
Нийт		31	12	8	7	1	3	72.8


Нийт арга хэмжээний хэрэгжилтийг газар, хэлтсээр тус бүрээр ангилж үзүүлбэл:

Зураг 1



Нийт арга хэмжээг хэрэгжилтийн хувиар үзүүлбэл:

Зураг 2



Гурав. Дүгнэлт

1. Хэрэгжилтийн хувьд авч үзвэл 2019 оны 3 дугаар улирлын байдлаар үр дүнтэй буюу 100 хувийн хэрэгжилттэй 12, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувийн хэрэгжилттэй 8, эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувийн хэрэгжилттэй 7, хэрэгжээгүй 1, үнэлэх боломжгүй 3 арга хэмжээ байна.

2. Дараах 40 хувийн биелэлттэй 7, хэрэгжээгүй 1 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэллээ. Үүнд:

Хүснэгт 3

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт	
7.5.3.	Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх Хэрэгжилтийн явц хувиар 20	<p>Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, техникийн зураг төслийг СМЕК компани боловсруулж, Концесс эзэмшигч “Нортерн рейлвэйс” ХХК-д хүлээлгэн өгсөн.</p> <p>Тус чиглэлийн төмөр замын чигийг ЗГ-ын 2017 оны 10 дугаар тогтоолоор батлуулсан.</p> <p>“Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” нөхцөлтэй концессоор хэрэгжиж буй Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын төслийн концесс эзэмшигч “Нортерн Рэйлвэйс” ХХК нь уг төмөр замын төслийн олон улсын банк, санхүүгийн байгууллагын шаардлага хангасан ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг гүйцэтгүүлэх, цаашид хамтран ажиллахаар БНХАУ-ын “Чайна гэжуба групп” корпорацитай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.</p> <p>Санамж бичгийн дагуу “Чайна гэжуба групп” корпораци нь тус төмөр замын төслийн олон улсын банк, санхүүгийн байгууллагын шаардлага хангасан ТЭЗҮ-ийг боловсруулж дууссан. Эрдэнэт-Овоотын 547,7км төмөр замын нарийвчилсан ТЭЗҮ-г боловсруулан ЗТХЯ-нд ирүүлсэн.</p> <p>УИХ-ын 2018.06.29-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор Эрдэнэт-Арцсуурь чиглэлийн 780 км төмөр замыг Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод нэмэлтээр оруулсан.</p> <p>УИХ-ын 2019 оны 41 дүгээр тогтоолоор Хөвсгөл аймгийн Цагаан-Уул, Цэцэрлэг, Шинэ-Идэр, Бүрэнтогтох сум, Завхан аймгийн Тэлмэн, Их-Уул сумын нутгийг дамнан орших Тэсийн гол, Булнайн нурууг байгалийн цогцолборт газрын ангиллаар улсын тусгай</p>	0



		<p>хамгаалалтад авсан.</p> <p>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 228 дугаар тушаалаар Эрчим хүчний яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтарсан ажлын хэсэг байгуулж Хужирын голын хөндийгөөр Эгийн голын усан цахилгаан станц төслийн авто зам, цахилгаан дамжуулах агаарын шугамын чигтэй зэрэгцүүлэн төмөр замын чигийг явуулахаар ажлын хэсгийн 2019.07.08-ны өдрийн №19/228/10 дүгнэлт гарсан. Концессын гэрээг сунгах хүсэлтийг Үндэсний хөгжлийн газарт хүргүүлээд байна.</p> <p>Тус чиглэлийн төмөр замын батлагдсан чиг нь Булнайн нуруу, Тэсийн голын хөндийгөөр 100 гаруй км дайрч байгаа тул хийгдсэн судалгаа, ТЭЗҮ-д өөрчлөлт орох шардлагын дагуу концесс эзэмшигч судалгааны ажлууд эхлүүлээд байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газар болон “Нортерн рэйлвэйс” ХХК-ийн хооронд байгуулсан Эрдэнэт хот-Овоотын уурхай чиглэлд төмөр замын суурь бүтцийн зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээг сунгах асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Үндэсний хөгжлийн газар болон бусад холбогдох төрийн байгууллагуудыг оролцуулсан Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.</p>	
7.1.7.	<p>Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120 км хатуу хучилттай авто зам Барилгын ажлын гүйцэтгэл хувиар 100</p>	<p>Зам барилгын ажлыг эхлүүлэх 06/18/2017 дугаартай зөвшөөрлийг 2017 оны 12 дүгээр сарын 26-ны өдөр олгосон. Үндэсний хөгжлийн газраас өгсөн тайлбараар концессын гэрээний дагуу Зөвлөхийн зардлыг холбогдох дансанд байршуулаагүй тул Зөвлөх барилгын ажлын талбай гараагүй байна. Концесс эзэмшигчээс далан, ухмал, хиймэл байгууламжийн ажил гүйцэтгэж байгаа бөгөөд ойролцоогоор нийт ажлын 20%-ийг хийж гүйцэтгэсэн талаар Үндэсний хөгжлийн газарт мэдээ өгсөн боловч эдгээр ажил нь Зөвлөхөөр баталгаажаагүй байна. Үүнтэй холбоотой эрх бүхий байгууллагаас шалгалт хийгдэж байгаа тул одоогоор зам барилгын ажлыг эхлүүлэх талаар тодорхой тов гараагүй байна.</p>	40
7.1.8.	<p>Байдрагийн гүүр-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам Барилгын ажлын гүйцэтгэл хувиар 100</p>	<p>Концессын “Барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр Хөрөнгө оруулалтын газраас /хуучнаар/ “Эрчим хүчний барилга угсралтын трест” ХХК-тай 2015.08.15-ны өдөр концессын гэрээ байгуулсан. Концесс эзэмшигч “Эрчим хүчний барилга угсралтын трест” ХХК нь гүйцэтгэгч “Монроуд” ХХК-тай гэрээгээ сунгасан бөгөөд 2018 оны 5 сарын 15-ны өдрөөс зам барилгын ажлыг эхлүүлсэн ба 12.9 хувийг хийж гүйцэтгэсэн. Засгийн газрын 2019.04.10-ны өдрийн хуралдаанаар уг концессын эзэмшигчийн эрх, үүргийг “Макс рөүд” ХХК-д шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Засгийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу гэрээний хэлцэл хийж, 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдөр “Макс рөүд” ХХК-тай концессын гэрээ байгуулсан бөгөөд концесс эзэмшигч “Макс рөүд” ХХК нь зам барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр, “Аварга зам” ХХК Зөвлөхөөр үргэлжлүүлэн ажиллаж байна. Барилгын ажлын талбайд ухмал, далангийн дүүргэлт, суурь, асфальтбетон хучилт, хиймэл байгууламж, гүүрийн ажил хийгдэж байна. Газар шорооны ажлын 60%, суурийн ажлын 21%, хойлойн ажлын 30%, гүүрийн ажлын 39%, хучилтын ажлын 4.7%-ийг хийж гүйцэтгээд байна. Нийт ажлын явц 39%-тай.</p>	40
7.2.3.	<p>“Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төслийг хэрэгжүүлэх Ажлын гүйцэтгэл хувиар 10</p>	<p>АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжих “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”-ийн хүрээнд хэрэгжих Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажлын ажлын зураг төслийг 2019 оны 03 дугаар сард эцэслэн боловсруулж АХБ-аас зөвшөөрөл авсан. Зам барилгын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах олон улсын тендерийг 5 багц хэсгээр 2019 оны 03 сарын 21-нд зарлаж, 05 дугаар сарын 02-ны өдөр нээсэн. Шалгарсан гүйцэтгэгч</p>	40



		компаниудтай 2019 оны 06 сарын 12-14-ны өдрүүдэд байгуулсан. Зам барилгын ажлыг 2019 оны 06 сарын 17-ны өдөр эхлүүлсэн. Тайлант хугацаанд нийт барилгын ажлыг гүйцэтгэл 22.3%-тай байна. Зам барилгын ажилд техник, технологийн хяналт тавих зөвлөхийн сонгон шалгаруулалтын ажлыг 2019 оны 01 сараас 05 дугаар сарын хугацаанд зохион байгуулж, шалгарсан зөвлөх компанитай 2019 оны 06 сарын 05-ны өдөр байгуулсан.	
7.3.5.	Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц Хэрэгжилтийн явц хувиар 30	Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 100 дугаар тушаалаар байгуулав. Ажлын хэсгийн хурлыг 2019.03.22-ны өдөр хуралдуулж ажлын хэсгийн төлөвлөгөөг хэлэлцэн батлав. Хөтөлбөрийг 2019 оны 9 сард батлуулах төлөвлөгөөтэйгээр ажиллаж байна. Үндэсний хөтөлбөрийн хоёр болон гурав дахь хувилбарыг боловсруулж яамны цахим хуудсанд байршуулан санал авсан. Ажлын хэсгийн гишүүд хуваарилсан чиглэлийн дагуу ХБББНЖ-д заасан хавсралтуудыг боловсруулан ажиллаж байна. Мөн НМТГ-тай хамтран тээврийн ухаалаг системийг нэвтрүүлэх талаар судлах, санал боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгийн гишүүд хуваарилсан чиглэлийн дагуу ХБББНЖ-д заасан хавсралтуудыг боловсруулан яамдаас санал авахаар ажиллаж байна. Мөн НМТГ-тай хамтран тээврийн ухаалаг системийг нэвтрүүлэх талаар судлах, санал боловсруулах ажлын хэсэг байгуулахаар санал хүргүүлэн ажиллаж байна.	40
7.3.6.	Тусгай замын автобус системийг (BRT) нэвтрүүлэх 1 дүгээр шатны барилгын ажил Хэрэгжилтийн явц хувиар 50	Төслийн удирдах хороо 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр хуралдаж төслийн явц, 2018, 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, 1,2,3 дугаар үе шатанд хэрэгжүүлэх тусгай замын автобусны коридорын талаар хэлэлцэв. Трас 2, 3 буюу ТЗА 2, 3 дугаар хэсгийн зээлийн хүрээнд хийгдэх ажлын бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлох ажлын хүрээнд санамж бичгийн төсөл бэлтгэгдэж байгаатай холбогдуулан Төсөл хэрэгжүүлэгч нэгжээс коридорын сонголттой холбогдуулан талбайн судалгаа болон газар чөлөөлөлтийн асуудалтай төлөвлөлтийн ажлуудыг хийгээд байна. ТЗА-ны дэд бүтцийн инженерийн нарийвчилсан зураг төсөл, УТС-ийн зураг төслүүдийг боловсруулах ажлын даалгаварын цар хүрээнд өөчлөлт оруулж дахин боловсруулж байна. Төслийн төлөвлөгөө, тайлан, биелэлтийг улирал бүр авч, мэдээлэл солилцон ажиллаж байна. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч томилогдоогүй улмаас төсөл зогсонги байдалтай байсан бөгөөд 2016 оны 06 дугаар сард төслийн зохицуулагчийг томилсон. Нийслэлийн бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орсонтой холбоотойгоор 2019 оны 06 дугаар сарын 14 өдрийн А/587 дугаар захирамжаар Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг шинээр байгуулсан. Уг удирдах хороонд тус яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга орж ажиллаж байгаа бөгөөд удирдах хорооны хурлаар төслийг эрчимжүүлэх талаар Нийслэлд чиглэл өгсөн. Удирдах хороогоор дараах асуудлыг шийдвэрлэсэн. Үүнд: 1. “Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн төсөл хэрэгжүүлэх хугацаа 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөр тасалбар болгон дуусаж байгаатай холбогдуулан төслийг хугацааг сунгах асуудлыг хэлэлцэв. 2. Төсөл хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, Худалдан авах ажиллагааны 2019 оны төлөвлөгөөний тодотгол, 2019 оны Санхүүгийн төлөвлөгөөний тодотголыг батлав. 3. Төслийн хэрэгжүүлэх нэгжийн ажиллагсдын хөлсөөр ажиллах гэрээний хугацааг Сангийн сайдын тушаалыг үндэслэн сунгах, төсөл хэрэгжүүлэх нэгжийг батлагдсан орон тооны дагуу шинэчлэн байгуулав.	



		1-р шатны коридорын хүрээнд инженерийн нарийвчилсан зураг төслийг гаргах зургийн тендерийг зарласан бөгөөд зөвлөх компанийг сонгох ажил хийгдэж байна. Барилгын ажлын тендерийн баримт бичгийг боловсруулж байгаа бөгөөд Азийн хөгжлийн банканд хүргүүлэхээр ажиллаж байна.	
7.5.4.	“УБТЗ” ХНН-ийн гол замын их засварын ажлыг гүйцэтгэх Хэрэгжилтийн явц хувиар 50	<p>2016 онд гол замын 17 км замд их засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>2017 онд гол замын 50 км замд их засвар хийж дууссан.</p> <p>2018 онд гол замын 50.1 км замд их засварын ажил хийсэн.</p> <p>2019 онд 2019 онд 50км төмөр замд их засварын ажил хийгдэхээр төлөвлөсөн. Их засварын ажлыг 2019 оны 06 дугаар сарын 26 өдрөөс 2019 оны 07 дугаар сарын 06-ны өдрүүдэд Хойт-Сүхбаатар хоорондын замд 5526,3 пог.м-г хийж гүйцэтгэсэн. Мөн урд чиглэлд 2019 онд 30000 пог.м буюу 30 км их засварын ажил төлөвлөснөөс 2019 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс эхлүүлэн 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар 10,2 км буюу нийт ажлын 30%-г хийж гүйцэтгээд байна</p>	40
8.3.1.	Улаанбаатар хот болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрыг түшиглэн хөгжих хот, суурин, хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх Боловсруулах ерөнхий төлөвлөгөөний тоо 1	<p>Бичигт хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд зам, тээврийн салбарын талаар тусгах саналыг БХБЯ-нд 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 03/2764 тоот албан бичгээр өгсөн. Баруун бүсийн тулгуур төв Завхан аймгийн Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд зам, тээврийн салбарын нийт 12 арга хэмжээний саналыг 2019-04-23-ны өдрийн 03/1991 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар Алтанбулаг, Замын-Үүд боомтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хэлэлцүүлэгт оролцон уг боомтуудад холбоотой зам, тээврийн төсөл, хөтөлбөрийн талаар танилцуулга хийсэн. Мөн Ерөнхий төлөвлөгөө боловсруулж байгаа төслийн багынхантай уулзалт зохион байгуулан шаардлагатай мэдээллээр ханган ажилласан.</p> <p>Сүхбаатар аймгийн Бичигт хилийн боомтын ерөнхий төлөвлөгөө боловсруулж байгаатай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яамнаас хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 03/2764 тоот албан бичгээр БХБЯ-д хүргүүлсэн. Мөн Монгол Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нэмэлтээр тусгуулахаар зам, тээврийн салбарт хэрэгжих төслүүдийн мэдээлэл, Бичигт боомтод логистикийн төв байгуулах саналыг 2019 оны 09 дүгээр сарын 20-ны 04/5008 тоот албан бичгээр Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлээд байна</p> <p>Монгол, Хятадын хилийн боомтын менежментийн хамтын ажиллагааны комиссын хоёрдугаар хуралдааны протоколын хэрэгжилт, гуравдугаар хуралдаанаар хэлэлцэх асуудалд зам, тээврийн салбараас тусгах асуудлыг Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн. Мөн Монгол, Хятадын хилийн боомтын менежментийн хамтын ажиллагааны комиссын гуравдугаар хуралдаан 2019 оны 9 дүгээр сарын 9-10 өдөр зохион байгуулахад зам, тээврийн яамны холбогдох албан хаагчид оролцсон.</p>	40

4. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2019 оны 3 дугаар улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай



40%-ийн, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай 70%-ийн үнэлгээтэй дараах арга хэмжээнүүдийг жилийн эцсийн хүрэх түвшинд хүргэхийг яамны газар, хэлтсүүд, харьяа байгууллагуудад;

- Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120 км хатуу хучилттай авто зам барихыг АЗБХЗГ-т;

- Байдрагийн гүүр-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам барихыг АЗБХЗГ-т;

- “Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төслийг 10 хувьд хүргэхийг АЗБХЗГ-т;

- Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 85 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэлийг 85 хувьд хүргэхийг АЗБХЗГ-т;

- Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замаас Мөст сум хүртэлх 20.3 км хатуу хучилттай авто зам барихыг АЗБХЗГ-т;

- Баянхонгор-Арвайхээр чиглэлийн авто замын огцом эргэлтийг өөрчлөх 4.4 км хатуу хучилттай авто зам барих;

- Улсын чанартай 15231 км авто зам, замын байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөлийг хангахыг АЗБХЗГ-т;

- Улсын чанартай авто замд байрлах 207 у/м төмөр бетон гүүрийн их засвар, шинэчлэлт хийхийг АЗБХЗГ-т;

- Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарц барихыг АЗБХЗГ, НЗДТГ-т;

- Баянзүрх дүүргийн 321 у/м болон Сонсголонгийн 289,4 у/м төмөр бетон гүүрийн барилгын ажил 90 хувьд хүргэхийг АЗБХЗГ, НЗДТГ-т;

- Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл шинэчлэлт 50 хувьд хүргэхийг АЗБХЗГ, НЗДТГ-т;

- Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 30 хувьд хүргэхийг АЗБХЗГ, НЗДТГ-т;

- Тусгай замын автобус (BRT) системийг нэвтрүүлэх 1 дүгээр шатны барилгын ажлыг 50 хувьд хүргэхийг АЗБХЗГ, НЗДТГ-т;

- “УБТЗ” ХНН-ийн гол замын их засварын ажлыг 50 хувьд хүргэхийг ТЗДТБХЗГ, “УБТЗ” ХНН-д;

- Улаанбаатар хот болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрыг түшиглэн хөгжих хот, суурин, хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийхийг БТГ-т;

- Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулахыг ТЗДТБХЗГ, “МТЗ” ТӨХК-д;

- Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын трассыг шинэчлэн батлуулахыг ТЗДТБХЗГ, Концесс эзэмшигч “Нортерн рейлвейс” ХХК-д;

2. Ховд, Өмнөговь аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх барилгын ажлын санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхийг АТБХЗХ, ИНЕГ-т тус тус зөвлөж байна.



Танилцсан:

Сайд	Б.Энх-Амгалан
Дэд сайд	Л.Халтар
Төрийн нарийн бичгийн дарга	С.Батболд
Төрийн захиргааны удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Б.Болор-Эрдэнэ
Бодлого, төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Ж.Сэрээтэр
Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Х.Оргил-Эрдэнэ
Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Г.Гантулга
Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	Б.Артур
Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Д.Мягмарсүрэн

Хянасан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	М.Энхболд
--	-----------

Боловсруулсан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн	Н.Буянт
---	---------